

Орон бүхий пролетар нар нэгдэгч! АНХ ДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Хын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 70 (2374)

1974 оны 9 дүгээр сарын 19

ПҮРЭВ

НАМЫН УЛС

ТӨРИЙН СУРГУУЛЬ

МАХН-ын улс төрийн сургуулийн 1974—1975 оны хичээлийн жилийн ажиллагаа удахгүй эхлэх гэж байна.

Тус аймгийн хэмжээгээр өнгөрсөн гурван жилд намын улс төрийн анхан, дунд шатны сургуульд 3300 шахам хүн суралцан төгсч 470 гаруй хүн онолын семинарт сууж намын бүх гишүүд, орлогчид, дээд боловсролтой сэхээтнүүд улс төрийн боловсролоор шат ахисан байна.

Өнгөрсөн хичээлийн жилд улс төрийн сургууль семинар нь хичээлийг амьдралтай холбох, арга хэлбэрийг баяжуулах замаар түүний үр нөлөөг улам сайжруулах, сонсогчдоос онол, улс төрийн боловсролоо дээшлүүлэх, дугуйлан семинарт оролцох идэвх чармайлт, хариуцлагыг дээшлүүлэх үндсэн зорилтын дор явагдав.

Аймгийн Намын хороо, суртал нэвтрүүлэгчдийн бүрэлдэхүүнийг сайжруулах, 3 суманд групп шалгалт хийж нийт сумдын улс төрийн сургуулийн хичээллэлт зохион байгуулалттай 2—3 удаа танилцаж үзлэгийн дүн, ололт дутагдлыг нийт намын байгууллага суртал нэвтрүүлэгчдэд мэдээлэх, суртал нэвтрүүлэгчидтэй харилцах шуудан, суртал нэвтрүүлэгчдээс сонсогчдын идэвх, ирцийн талаар байгууллагуудтай харилцах хуудас бий болгох, тэргүүний суртал нэвтрүүлэгчдийн туршлагыг дэлгэрүүлэх, ухуулагчдад тусламж сэтгүүл гаргах, гарын авлага мэдээлэл хүргүүлэх зэрэг нилээд ажил зохиолоо.

Алтанбулаг, Заамар, Борнуур, Баянзүрх, Баянцогт сумын намын байгууллага улс төрийн сургуулийг үйлдвэр, аж ахуйн газруудтай холбоотой ажиллуулах, сонсогчдын ирц идэвхийг сайжруулах талаар бусдаас илүү үр дүнд хүрчээ.

Энэ хичээлийн жилд улс төрийн сургуулийн үр дүнг сайжруулах талаар намын байгууллага, суртал нэвтрүүлэгчдийн өмнө өндөр шаардлага тавигдаж байна. Сонсогчдыг ялхгүй шалтгаанаар хичээлээс чөлөөлдөг, суртал нэвтрүүлэгч сонсогчдыг хичээлтэй өдрүүдэд ажилд томилж сонсогчдыг хохироож байгаа явдлыг эцэс болгох хэрэгтэй.

Шинэ хичээлийн жилд намын улс төрийн сургуулийн онолын хичээлийг амьдрал дахь судалгаа туршлагаар баяжуулан үр нөлөөг нь дээшлүүлэх, сонсогчдын идэвх хариуцлагыг өндөржүүлэхээр дэвшүүлсэн өнгөрсөн жилийн зорилтыг улам бататган хэрэгжүүлэх, улс төрийн сургууль онолын семинарын программыг бүрэн хангаж хичээлэх нь чухал байна.

Намын байгууллага—суртал нэвтрүүлэгч, суртал нэвтрүүлэгч—сонсогчдын холбоо харилцааг сайжруулж, идэвх сонирхлыг нь дээшлүүлэх, туршлага санаачлага бүрийг дэмжин дэлгэрүүлэх ажлыг чухалчлан анхаарвал зохино.

Орчин үед олон улсын амьдралд гарч бий нааштай алхам, ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас энх тайвны тусын тулд оруулж байгаа хувь нэмэр, ололт амжилт, манай орны гадаад дотоод амьдралын баримтыг сонсогчдод гүн гүнзгий тайлбарлан таниулж байх нь сонсогчдын гүн бат мэдлэгийн нэг үндэс болно.

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ын тунхагласны 50 жилийн түүхт ойн энэ онд намын улс төрийн бүх шатны сургууль, онолын семинар, МХЗЭ, УЭ-ийн сургууль, хөдөлмөрчдөд эдийн засгийн мэдлэг эзэмшүүлэх сургууль, өвөл цагийн хүмүүжлийн ажлын бэлтгэлийг бүрэн хангаж зохион байгуулалт сайтай эхлүүлэн, өндөр шаардлага тавьж чанартай хичээллүүлэх нь намын байгууллагуудын чухал зорилт мөн.

Байгаль хамгаалах сард

Туршлагатай ой хамгаалагч

Баянчандмань хорооны ой хамгаалагч Д.Дугар сүүлийн 18 жил ой хамгаалагчийн ажил хийж байна.

Тэрээр ойн идэвхтэнтэй холбоотой ажиллаж ойг хамгаалах хууль дүрэм зааврыг олон түмэнд тайлбарлан таниулах ажлыг сайн зохиодог юм.

Д.Дугар ойг шалгах төлөвлөгөөг сар тутам хийж, ойн эргүүлийг ойрын ба холын гэж хоёр чиглэлээр схем зураг гаргаж хийдэг аж.

Ой хамгаалагчаараа ажилласан хугацаанд 50 гаруй удаа зөрчил илрүүлж засчээ. Түүний хариуцсан газарт нэг ч удаа ойн түймэр гараагүйн дээр ойн орлогын төлөвлөгөөг жил дараалан 110—125 хувиар биелүүлж иржээ.

Ой хамгаалагч Д.Дугар ойн байгууллагын 50 жилийн ойг ойн орлогын 1974 оны төлөвлөгөөг давуулан биелүүлсэн амжилтаар угтаж, сүүлийн хагас жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлэхээр чармайн ажиллаж байна.

Б. ГАЛСАН

ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙД

Зөөхийн намар

Сор нь халиуран бууралтах ухаа толгод талхонд, түрүүгээ дааж ялан гунхалзах ургацтай тариалангийн талбай өдөржин шөнөжин жигдхэн нүргэлэх комбайны дуу, талбайгаас үтрэмээр Баруун, Зүүн харааг зорьсон тэвш дүүрэн будаатай тээврийн машины цуваа, оюутан залуусын хөгжөөнт дуу хоолой их хөдөлмөрийн ид хавыг илтгэнэ.

Зөөхийн бригадын дарга Намсрай, тал дүүрэн шаргалтах тариаг нүдний хараа сунган харж:

—Бид ургац хураалтын ажлаа богино хугацаанд чанартай дуусгахын тулд 14 комбайныг 2 салаа болгон зохион байгуулж арван тав дахь намрынхаа ургац хураах ажилдаа ороод байна.

Манай бригад V таван жилийн төлөвлөгөөг 117 хувиар биелүүлсэн. Зөөхий ёстой цэлгэр хөндий шүү... Энэ их талд чинь тариалангийн 5324 га талбай байгаа юм.

Үүнээс энэ жил 3379 га-д улаанг буудай, 212 га-д нь бог будаа тариалж 38653 центнер ургац хурааж авах төлөвлөгөөтэй юм.

Мөн зуны уринш хагалааг 1733 га-д, хөрс боловсруулалтыг 3466 га-д 100 хувь хийж дуусгалаа.

Одоо 2736 га талбайн ургацыг ангилан хадаж 719 га талбайн тариаг цайруулж, 7190 центнер үр тариа аваад байна.

Манай бригад МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооноос бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлэх тухай гаргасан тогтоолыг биелүүлэх үндсэн дээр үр тариа хураах төлөвлөгөөг давуулан биелүүлэх хүн нэг бүрээр үүрэг амлаалт аварх уул ж тэдний хооронд социалист уралдааныг 7, 14 хоногоор зарлан дүгнэж байна.

Үүний үр дүнд 1 дүгээр долоо хоногийн байдлаар БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, МАХН-ын гишүүн М. Чойжамц ахлагчтай 1 дүгээр салааны хамт олон 981 га талбайн ургац ангилж 404 га-гийн тариа цайруулж 4370 центнер үр тариа хурааж төлөвлөгөөгөө 120 хувиар биелүүлээ.

Комбайнчдын дотроос БНМАУ-ын дөрвөн удаагийн II аварга комбайнч С. Баасанхүү, БНМАУ-ын хошой аварга, МХЗЭ-ийн гишүүн Жанцансэнгээ, БНМАУ-ын аварга Л. Пашка нарангилан хадланд өдөр бүрийн нормоо 105—120 хувиар биелүүлж байна.

Цайруулалтанд комбайнч Д. Самбуу дөрвөн өдөрт 167 га талбайн ургац цайруулж 999 тонн үр тариа хураан авч төлөвлөгөөгөө 230 хувиар биелүүлсэн зэрэг амжилтаар хамт олноо хошуучилж яана гэж ярих.

Ийнхүү Зөөхийн хөндийд ургац хураах ажил ид өрнөж моторын дуу ажилсаг хамт олны дуу хоолойтой хоршин ажил хөдөлмөрийн их эрч амжилт бүтээлийн дээдээр ургацын далай нь давалгаалж байна.

Д. ДОРВОНЖИН

ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭН



Байдэлгэр сумын „Хэрлэг-баян“ нэгдлийн ноогчин, илгээлтийн эзэн Ж. Долгор байцаа харууцан ажиллаж энэ жил арвин ургац авч төлөвлөгөөгөө үлэмж давуулах боломж олоод байна.

О. СУМБЯА-гийн авсан гэрэл зураг.

Сурагчдын туслалцаа

1974 оны төлөвлөгөө ёсоор Эрдэнэсант сумын хэмжээгээр бэлтгэх ёстой 850 ширхэг зурагны арьсны төлөвлөгөөг тус сумын 8 жилийн дунд сургуулийн пионер сурагчид давуулан биелүүлэв.

Сурагчид нийтдээ 1000 ширхэг зурагны арьсыг ХБ ангид тушаажээ.

Энэ ажилд багш Санжаадулам, Дашдэмбэрэл нарын удирдсан ангийн сурагчид бусдаасаа илүү идэвхтэй оролцсоны дотор сурагч Сэргэлэн, Гансүх, Нармандах нар 7—10 ширхэг арьс тушааж бусдыгаа хошуучлав.

Мөн сумын хэмжээгээр ямааны хялгасны төлөвлөгөө 58 кг дутуу байсны сурагчид нэг өдрийн суботник хийж бүрэн биелүүлж сайхан амжилт гаргав.

О. МЯГМАРЖАВ

Бүх ард түмний социалист уралдаан

УРАЛДААНЫ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭ

Аймгийн Хүнсний үйлдвэр, Хотын Худалдааны трест, Нэгдэл дундын үйлдвэрт социалист уралдааныг хэрхэн зохион байгуулж удирдаж буй талаар, саяхан тус сонин редакци, УЭ-ийн зөвлөл хамтарсан үзлэг хийв.

Үзлэгийн дүнг дор нийтлэлээ.

Аймгийн Хүнсний үйлдвэр, Хотын худалдааны трест, Нэгдэл дундын үйлдвэр социалист уралдааныг эрхлэх комиссыг 3—9 хүний бүрэлдэхүүнтэй гээр байгуулж уралдаанд ажилчдаар амлалт үүрэг авахуулан ажиллажээ.

Уралдааны үүрэг, үйлдвэрлэлийн төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг жигд биелүүлэхийн тулд Хүнсний үйлдвэр ажилчдын дунд зарласан уралдааныг сар бүр, цех тасгуудын уралдааныг улирлаар амлалт гүйцэтгэлийг харьцуулан дүгнэдгийн дээр цаг үеийн сэдвээр нэрэмжит болзолт уралдааныг 3 удаа зарлан дүгнэж ажилласны дунд энэ оны эхний 8 сарын төлөвлөгөөг 110 хувиар биелүүлж, 1974 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 45 хогогийн өмнө биелүүлэх боломжийг олсон байна.

Тус үйлдвэр бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхийн тулд олон нийтийн байгууллагуудын үзлэгийг сар бүр явуулж дутагдал гарсан даруй хэ-

тайхан эхлэлтүүд гарчээ.

Хотын худалдааны трест ажилчдын уралдааныг сар бүр, гуанз дэлгүүрийн уралдааныг улирлаар дүгнэхээр зарласан боловч аль алий нь хоёроос илүү дүгнээгүй байв.

Зарласан уралдааныг дүгнээгүй өдий хүрснээ өнөө жил зарцуулахаар төлөвлөсөн шагналын фонд хагас жил хэхэд 70 төгрөгөөр хэтэрсэн гэдгээр тайлбарлаж байлаа.

Уралдааныг ийнхүү ор нэр болгосноор тус трестийн эхний хагас жилийн төлөвлөгөө 38 мянган төгрөгөөр 8 сарын төлөвлөгөө 101 мянган төгрөгөөр тасарчээ. Зарласан уралдааныг дүгнэдэггүйгээс хувь хүмүүсээс уралдааны амлалтаа хүлээх хариуцлага санаачлага суларч байгаа нь төлөвлөгөө тасалдах, зохиосон ажил эхлэл төдий өнгөрөх, үйлчилгээний соёл ариун цэвэр хэвийн биш байх зэргээр илэрч байна.

Тэр ч байтугай тус трестийн морин тэрэгчин, сахиул зэрэг 10 гаруй хүмүүс энэ оны бүх ард түмний уралдаанд үүрэг амлалт авсангүй.

Гэтэл дээрхи ажилчидтай ойр дөхүү ажилтай хүнсний үйлдвэрийн ачаа ачигч С.Хорлоо талхчины III зэргийн мэргэжил эзэмших, оройн сургуулийн VI анги төгсөх, орос үг

200-г сурах, тэргүүн туршлага эзэмших, хуримтлал оруулах зэрэг 12 төрлийн үүрэг авч 80 гаруй хувийг нь биелүүлээд байлаа. Хотын худалдааны трестэд ажлаас халагдсан солигдсон хүмүүсийн оронд орж ажиллагсад түрүү ажиллагчийн авсан уралдааны үүрэг амлалтан дээр ажиллаж байгаа нь уралдааныг дэндүү хэлбэрдэж байгаагийн баримт юм. Өнөө жилийн бүх ард түмний уралдаанд Хүнсний үйлдвэрийн 80, Худалдааны трестийн 157, НДУ-ийн 170 хүн амлалт авчээ. Ажилчдын амлалтын биелэлтийг дүгнэхдээ Хүнсний үйлдвэр, Хотын худалдааны трест зөвхөн нормын биелэлт амлалтын хувийг харьцуулж бусад үүргийн биелэлтийг орхигдуулан өрөөсгөл дүгнэж байгаагаас ихэнх хүмүүс амлалтаасаа юу нь биелсэн юуг нь биелээгүйг мэдэхгүй байна.

Тэр ч байтугай Нэгдэл дундын үйлдвэрийн УЭ-ийн хорооны (дарга нь Н.Долгор) тэргүүлэгчид энэ жил ажилчдын дунд социалист уралдааныг хэдэн удаа ямар хэлбэрээр явуулж дүгнэснээ ч мэдэхгүй, дүгнэсэн баримт материал ч байхгүй байна. Социалист уралдааны комиссыг инженер Ширмэнхуягаар даргалуулан байгуулсан боловч ажлын төлөвлөгөө, зохиосон

ажилгүй явж иржээ.

Энэ бүхэн бол олон түмний итгэл, сонгуульт ажлын өмнө хүлээх хувийн хариуцлага алдсан ноцтой дутагдал мөн.

Түүнчлэн НДУ-ийн УЭ-ийн хорооноос СХ-ийн хөдөлгөөнийг өрнүүлж удирдах талаар хийсэн ажил тун бага байна.

Аймгийн Хүнсний үйлдвэр социалист уралдааны дээд хэлбэр болсон СХБ-д нийт ажиллагсдын 98 хувийг хамруулж I, II алдар медалийн үүргээ биелүүлсэн байхад, Хотын худалдааны трест 1971 онд СХБ 8-д зуу шахам гавшгайч байсан бол одоо 2-хон бригадад 10 гаруйхан гавшгайч үлдэж бусад нь тарсан байлаа.

Социалист уралдааны дээд хэлбэр СХ-ийн хөдөлгөөнд иймэрхүү байдлаар хандаж хэрхэвч таарахгүй.

Иймээс социалист уралдааныг ажилчдын дунд шинэ шинэ агуула, хэлбэрээр баяжуулан өрнүүлж, тухай бүр дүгнэж, нийтэд сурталчлах ажлыг сайжруулан, уралдааны үр нөлөөг эрс дээшлүүлэх явдал дээрх 3 газрын нам, захиргаа, УЭ-ийн байгууллагын чухал зорилт болж байна.

Аймгийн УЭ-ийн зөвлөлийн ажилтан
Д. Амаржаргал
«Анхдугаар таван жил»
сонин тусгай сурвалжлагч Ш. ЦЭРЭНДОО

УРАЛДААНЫ ГЭРЭЭ

Уралдааны гэрээ нь социалист уралдаанд авсан үүргээ хугацаанд нь биелүүлэхийн тулд харилцан уралдагч байгууллага, хамт олны гүйцэтгэх үүргийг тодорхойлж уралдаанд оролдогч байгууллагын төлөөлөгчдийн ба бүх ажилчдын хурлаар батлан, уралдаанд хугацаанд мөрдөж ажиллах албан ёсны баримт бичиг юм. Тус аймгийн үйлдвэр аж ахуйн газар уралдааны гэрээ байгуулан ажиллаж зохих амжилт гаргаж байна.

Аймгийн ХБУ газар, Хүнсний үйлдвэр, Тээврийг удирдах газар, Ойн аж ахуй, Нийтийн аж ахуйн үйлчилгээний газруудын хамт олон уралдааны гэрээ байгуулан, тус тусын байгууллага үүрэг амлалт авч, уралдааны гэрээний явцыг сар бүр дүгнэж байна.

Ер нь уралдааны гэрээ-

ний агуулгыг чанаржуулж, хэлбэрийг олшруулж ажил төрлийн холбоо бүхий цех, тасаг, бригад, ферм, үйлдвэр, байгууллагын хооронд гэрээг байгуулахын хамт нэг үйлдвэр, байгууллагын доторх тасаг, цех, хүмүүсийн хооронд уралдааны гэрээ байгуулж ажиллавал социалист уралдаанд авсан үүргээ сар улиралд тогтмол биелүүлж ажлын амжилт гаргахад зохих шинж түүхэц болно.

Социалист уралдааны гэрээгээр авч байгаа үүргэнд тодорхой асуудлыг тусгаж, уралдааны явцад гарсан ололт амжилт, тэргүүн туршлагыг солилцох, уралдааны шинэ арга хэлбэрийг эзэмших онол практикийн бага хурал, үйлдвэрлэлийн зөвлөлгөөнөөр хэлэлцэх зэрэг арга хэмжээ авах нь зүйтэй.

Мөн шинжлэх ухаан техникийн ололтыг үйлд

вэрлэлд нэвтрүүлэх талаар хамтарч ажиллах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн хийх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, шинжлэх ухааны үндэстэй хөдөлмөр зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох зэрэг гол тогцоо асуудлыг олж бие биенийхээ өмнө амлалт авах, харилцан үздэг шалгалт явуулах замаар ажлаа сайжруулахад чиглэгдсэн зүйлийг гэрээнд тусгаж өгөх хэрэгтэй. Одоо тус аймгийн үйлдвэр, аж ахуй, ХАА зэрэг олон байгууллага, хөдөлмөрийн хамт олны хооронд гэрээ байгуулах ажил өрнөж байна.

Иймээс үйлдвэр, ХАА, соёлын газруудын нам, захиргаа, олон нийтийн байгууллага социалист уралдааны гэрээний үүргийн биелэлт, түүнийг зохион байгуулах ажлыг тодорхой удирдан дэмжин туслах явдал чухал байна.

Ж. ТӨМӨРСҮХ

ГАВШГАЙЧ



Аймгийн НААУ-ний Газрын халуун усны угаалгын цехийн индүүдэгч А. Должинсүрэн 12 жил ажилласан туршлагатай тэргүүний ажилчин юм.

Тэрээр V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жил 5 сард 5 жил 6 сарын ажил хийж «V таван жилийн гавшгайч» тэмдгийн болзол хангав.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧИЙН АВСАН ГЭРЭЛ ЗУРАГ.



Аймгийн Хүнсний үйлдвэрийн нарийн боовны цехийн ажилчин П. Отгоо V таван жилийн төлөвлөгөөг 1 жил 4 сарын өмнө 106,5 хувиар биелүүлж «V таван жилийн гавшгайч» тэмдгийн болзлыг хангаад байна.

Зураг дээр:
П.Отгоо ажил дээрээ байгаа нь.
Ш. ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг.

ТООНЫ ХЭЛЭЭР

■ Аймгийн хэмжээгээр 1974 оны бүх ард түмний социалист уралдаанд 16990 гаруй хүн үүрэг амлалт авсаны дотор 800

шахам хүн 1—5 жилээр тооцоотой үүрэг аван ажиллаж уралдаанд авсан амлалтаа амжилттай биелүүлж байгаагийн дотор

140 гаруй хүн V таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлж V таван жилийн гавшгайч тэмдгийн болзол ханга-
лаа.

